



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос хэрэгжүүлж буй "Бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллого явуулж цахим бүртгэл мэдээллийн системийг боловсронгуй болгох" ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	С.Аригуун	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	Ц.Мөнхбат	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын мэргэжилтэн
	Г.Цогтдэлгэр	Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын Системийн хөгжүүлэлтийн хэлтсийн ажилтан;
	Ж.Баярмагнай	Цаг уур, орчны шинжилгээний газрын Орчны шинжилгээний хэлтсийн мэргэжилтэн
	С.Алтанзул	Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Давхарбаяр	Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Ажлын албаны ажилтан
Нарийн бичгийн дарга:	Д.Шийтэр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Энэхүү тушаалын 1 дүгээр зүйлд заасан ажлын явц, үр дүнг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Ажлын хэсэг /С.Аригуун/-д даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  С.ГАНТӨМӨР

